

**ОЛОН ХҮҮХЭД ТӨРҮҮЛЖ ӨСГӨСӨН ЭХИЙГ УРАМШУУЛАХ
ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ
АНХНЫ ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ БЭЛТГЭСЭН ТАЛААРХ ХҮНИЙ ХӨГЖИЛ,
НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2026 оны 05 дугаар
сарын 12-ны өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулуун

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа, Х.Баасанжаргал, Б.Баярбаатар, Б.Уянга, С.Эрдэнэбат, С.Эрдэнэболд нарын 2025 оны 06 дугаар сарын 24-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурал 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн нэгдсэн хуралдаанаараа хэлэлцэн шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Байнгын хороо 2026 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн хуралдаанаараа Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10 дахь хэсэгт заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төсөлтэй холбогдуулан Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны 2025 оны 07 дугаар тогтоолоор байгуулагдсан ажлын хэсгээс гаргасан саналуудыг нэг бүрчлэн хэлэлцэж, дараах санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд танилцуулж байна. Үүнд:

Хуулийн төслийн хүрээнд “1 нас хүрсэн байх” гэсэн шалгуурыг хасах нь зөвхөн хүн амын өсөлтийг дэмжих бодлогын асуудал бус, мөн хүүхэд төрүүлсэн эхчүүд болон хүүхдүүдийг нөхцөл байдлаар нь ялгаварлан гадуурхах эрсдэлийг бууруулах, хүүхэд бүрийн үнэ цэнийг ижил түвшинд хүлээн зөвшөөрч, олон хүүхэд төрүүлсэн эхийг урамшуулах болон амьдралын нөхцөл байдал, эрүүл мэндийн эрсдэл, хүүхдийн эндэгдэл зэрэг эмзэг асуудлын улмаас зарим эхчүүдийн төрийн дэмжлэгт хамрагдаж чадахгүй байгаа асуудлыг шийдвэрлэнэ гэж Байнгын хороо үзлээ.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа “1 нас хүрсэн байх” гэсэн шалгуурыг хасах асуудлыг хэлэлцэхийг дэмжиж байгаа ч хууль нөхөн үйлчлэхгүй байх эрх зүйн нийтлэг зарчим алдагдахгүй байх, нийгэмд буруу хүлээлт үүсгэхгүй байхад онцгой анхаарах шаардлагатайг, алдарт эхийн одонтой холбоотойгоор хүүхдээ төрүүлсний дараа үрчлүүлэх, асрамжийн газарт өгөх зэрэг асуудалд бодлогын түвшинд анхаарахын зэрэгцээ нярайн болон бага насны хүүхдийн эндэгдлийг бууруулах зорилгоор төрөөс нярайн сувиллын үйлчилгээг дэмжих шаардлагатайг дурдаж хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэхийг хүслээ.

Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг Та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

ХҮНИЙ ХӨГЖИЛ, НИЙГМИЙН
БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ



Л.ЭНХНАСАН



**ОЛОН ХҮҮХЭД ТӨРҮҮЛЖ ӨСГӨСӨН ЭХИЙГ УРАМШУУЛАХ ТУХАЙ
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН
ТАЛААРХ ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН ТОМЬЁОЛ**

Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны дэмжсэн санал:

1.Төслийн 1 дүгээр зүйлийн “3.2 дахь хэсгээс” гэсний дараа “тэр үед гурав хүртэлх насанд нь” гэж нэмэх.

**Санал гаргасан:Улсын Их Хурлын гишүүн
О.Саранчулуун, Н.Алтаншагай, Д.Бум-Очир,
Д.Ганмаа, М.Ганхүлэг, Ц.Мөнхтуяа,
М.Сарнай, Г.Хосбаяр, Л.Энхнасан
/Цаашид “Ажлын хэсэг” гэх/**

2.Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах.

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Санал гаргасан:Ажлын хэсэг

---oOo---